

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ (2021 он)

1. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202101/01. ИНЕГ-т . /Safety recommendation 202101/01. МСАА/.

Монгол Улсын агаарын зайд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний аюулгүй ажиллагааг найдвартай хангахын тулд үйлдвэрлэгч Indra Sistemas S.A. компанитай хамтран ажиллаж Нислэгийн хөдөлгөөний ажиглалтын удирдлагын Aircon 2100 автоматжуулсан системд гарсан доголдол, дутагдлыг бүрэн засварлах, үйл ажиллагааг нь хэвийн явуулах тогтолцоог бүрдүүлэх.

2. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202101/02. ИНЕГ-т . /Safety recommendation 202101/02. МСАА/.

Монгол Улсын агаарын зайд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний аюулгүй ажиллагааг найдвартай түвшинд хангахын тулд бие даасан нөөц нислэгийн хөдөлгөөний ажиглалтын удирдлагын автоматжуулсан системийг бүрдүүлэх.

3. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202101/03. ИНЕГ-т . /Safety recommendation 202101/03. МСАА/.

Улаанбаатар Ойртолтын бүсэд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний найдвартай ажиллагааг хангахын тулд ИКАО-ын DOC 9684 “Manual of the Secondary Surveillance Radar Systems” болон DOC 9924 “Aeronautical Surveillance Manual”-ын шаардлагын дагуу Ойртолтын удирдлагын ажиглалт (terminal radar)-ын зориулалтын системийг бүрдүүлэх, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх.

4. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202101/04. ИНЕГ-т . /Safety recommendation 202101/04. МСАА/.

Нислэгийн хөдөлгөөний удирдлагын дадлагажуур (Бүс, Ойртолт, Аэродром)-ыг Нислэгийн удирдагчийн ажлын байрны тоног төхөөрөмжтэй ижил түвшинд, шаардлага хангасан хэмжээнд тоноглож үйл ажиллагаандаа ашиглах.

5. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202102/05. ИНЕГ-т . /Safety recommendation 202102/05. МСАА/.

Ми-8АМТ нисдэг тэрэгний Периодическое техническое обслуживание, Форма Ф4-500+20 техник үйлчилгээг хийх эрхийг дахин шалгаж дүгнэлт гарган техник үйлчилгээний хүрээг тогтоох.

6. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202103/06. Монголиан Эйрвэйз ХХК, ИНЕГ-т . /Safety recommendation 202103/06. Mongolian Airways LLC, МСАА/.

Нислэгийн өмнө навигацийн болон түлшний тооцооны дагуу төлөвлөлт хийх, төлөвлөлтийн дагуу нислэгийг гүйцэтгэх, нислэгийн үед NAVLOG хөтлөх .

7. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202103/07. Монголиан Эйрвэйз ХХК, ИНЕГ-т . /Safety recommendation 202103/07. Mongolian Airways LLC, МСАА/.

AS350 В3 маягийн нисдэг тэрэгний нислэг, техникийн ашиглалтын нөхцөл байдал/нэг нисгэгчтэй, авто ажиллагаагүй/-д тохируулан онцгой тохиолдлын үед ашиглах гарын авлага /QRH/ боловсруулж хэрэгжүүлэх.

8. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202103/08. Монголиан Эйрвэйз ХХК, ИНЕГ-т . /Safety recommendation 202103/08. Mongolian Airways LLC, MCAA/.

Үйлдвэрийн 8442 дугаартай Н125(AS350 В3) маягийн нисдэг тэрэгний Их бие, хөдөлгүүр түүний эд анги, системүүдэд хэт ачааллын дараах үзлэг, үйлчилгээг хийж дүгнэлт гаргах, ашиглах

9. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202107/09. ИНЕГ, Хан-бумбат нисэх буудалд. /Safety recommendation 202107/09. MCAA, Khan-Bumbat Airport/.

Аэродром орчмын хөрсний гадаргуй, цаг агаарын нөхцөл байдлаас хамааруулж Хан-бумбат нисэх буудлын аэродромын хөөрч буух зурвас болон явгалах замын хажуугийн хөвөөг хийж ашиглах.

10. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202107/10. ИНЕГ, МИАТ ХК, Ханбумбат нисэх буудалд. /Safety recommendation 202107/10. MCAA, MIAT Mongolian Airlines, Khan-Bumbat Airport /.

Шороо, тоосжилт ихтэй аэродромд байнгын нислэг үйлдэх, ашиглахтай холбогдуулан агаарын хөлгийн хөдөлгүүрийн найдвартай ажиллагааг хангах тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.

11. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202107/11. ИНЕГ-т. /Safety recommendation 202107/11. MCAA/.

Агаарын тээврийн МИАТ ХК-ийн нислэг, техник үйлчилгээний үйл ажиллагааг агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ/АОС/-ний хүрээнд шалгаж баталгаажуулах.

12. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202107/12. ИНЕГ, МИАТ ХК-д. /Safety recommendation 202107/12. MCAA, MIAT Mongolian Airlines /.

Бодит байдалд суурилсан сургалт /Evidence-Based Training/-ын хөтөлбөрийг боловсруулж нисгэх багийн гишүүдийг сургаж бэлтгэх.

13. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202109/13. ИНЕГ-т. /Safety recommendation 202109/13. MCAA /.

Иргэний нисэхийн холбогдох дүрэм, Нисэхийн Мэдээллийн Эмхэтгэл /НМЭ/-д “Агаарын зайг нисэхэд ашиглах тухай Монгол Улсын Хууль”-ийн 4.1.2. заалт болон Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2010 оны 6 дугаар сарын 10-нд байгуулсан гэрээний 21-р заалттай холбогдол бүхий мэдээллийг тусгах.

14. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202109/14. ИНЕГ-т. /Safety recommendation 202109/14. MCAA /.

Гадаад улсын харьяат нисгэгчийг Монгол Улсад нислэг үйлдэх эрх, үнэмлэх олгох болон баталгаажуулахад тавигдах шаардлагыг боловсронгуй болгох тусгай хөтөлбөр, заавар боловсруулж хэрэгжүүлэх.